

Жилийн үйл ажиллагааны тайлан /маягт 1/

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.

<p><i>Тайлагнах хугацаа /Жишээ нь: 2020 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 3 дугаар сарын 31-ний өдөр/</i></p>	<p>2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдөр</p>
<p><i>Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар</i></p>	<p>Нэр: “ЛэндМН ББСБ” ХК УБГД: 000166216 Үнэт цаасны код: MN0LEND05453 Утасны дугаар: 77222949, 77070101</p>
<p><i>Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр</i></p>	<p>“Монголын Хөрөнгийн Бирж” ХК</p>
<p><i>Бизнесийн үйл ажиллагааны салбар</i></p>	<p>Санхүүгийн салбар – Банк Бус Санхүүгийн Салбар</p>
<p><i>Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг</i></p>	<p>800,000,000 ширхэг (эргэлтэд 739,301,683 ширхэг)</p>
<p><i>Жилийн тайланг бэлтгэсэн, хянасан албан тушаалтны нэр</i></p>	<p>Жилийн тайланг бэлтгэсэн: Хууль, яаман шийцүүлэлтийн мэргэжилтэн Х.Хулан Жилийн тайланг хянасан: ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга Б.Оюунболд</p>

1.	Тайлант жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/																																																																	
	Санхүүгийн байдлын үзүүлэлт	<p>2023 оны бүтэн жилийн санхүүгийн тайланг хавсаргав.</p> <p>Санхүү байдлын тайлан /Нэгтгэсэн/:</p> <table border="1"> <thead> <tr> <th>Хөрөнгө /тэрбум төгрөг/</th> <th>2021 /аудитлагдсан/</th> <th>2022 /аудитлагдсан/</th> <th>2023 /аудитлагдсан/</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө</td> <td>4.90</td> <td>5.22</td> <td>7.89</td> </tr> <tr> <td>Зээлийн багц (цэвэр)</td> <td>32.43</td> <td>69.59</td> <td>123.46</td> </tr> <tr> <td>Бусад хөрөнгө</td> <td>0.76</td> <td>1.05</td> <td>0.51</td> </tr> <tr> <td>Үндсэн хөрөнгө</td> <td>0.76</td> <td>0.59</td> <td>1.25</td> </tr> <tr> <td>Билет бус хоршо</td> <td>0.45</td> <td>0.40</td> <td>0.36</td> </tr> <tr> <td>Нийт хөрөнгө</td> <td>39.30</td> <td>76.85</td> <td>133.47</td> </tr> </tbody> </table> <table border="1"> <thead> <tr> <th colspan="4">Өр төлбөр болон эздийн өмч /тэрбум төгрөг/</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Өр төлбөр</td> <td>19.49</td> <td>52.63</td> <td>90.74</td> </tr> <tr> <td>Эх үүсвэр</td> <td>15.07</td> <td>45.96</td> <td>79.29</td> </tr> <tr> <td>Хоёрдогч өглөг</td> <td>2.95</td> <td>2.95</td> <td>2.95</td> </tr> <tr> <td>Бусад өглөг</td> <td>1.47</td> <td>3.72</td> <td>8.50</td> </tr> <tr> <td>Эздийн өмчийн дүн</td> <td>19.81</td> <td>24.22</td> <td>42.73</td> </tr> <tr> <td>Хувьцаат капитал</td> <td>8.48</td> <td>8.48</td> <td>8.48</td> </tr> <tr> <td>Хуримтлагдсан ашиг</td> <td>11.33</td> <td>15.74</td> <td>34.25</td> </tr> <tr> <td>Нийт өр төлбөр болон эздийн өмч</td> <td>39.30</td> <td>76.85</td> <td>133.47</td> </tr> </tbody> </table>	Хөрөнгө /тэрбум төгрөг/	2021 /аудитлагдсан/	2022 /аудитлагдсан/	2023 /аудитлагдсан/	Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө	4.90	5.22	7.89	Зээлийн багц (цэвэр)	32.43	69.59	123.46	Бусад хөрөнгө	0.76	1.05	0.51	Үндсэн хөрөнгө	0.76	0.59	1.25	Билет бус хоршо	0.45	0.40	0.36	Нийт хөрөнгө	39.30	76.85	133.47	Өр төлбөр болон эздийн өмч /тэрбум төгрөг/				Өр төлбөр	19.49	52.63	90.74	Эх үүсвэр	15.07	45.96	79.29	Хоёрдогч өглөг	2.95	2.95	2.95	Бусад өглөг	1.47	3.72	8.50	Эздийн өмчийн дүн	19.81	24.22	42.73	Хувьцаат капитал	8.48	8.48	8.48	Хуримтлагдсан ашиг	11.33	15.74	34.25	Нийт өр төлбөр болон эздийн өмч	39.30	76.85	133.47
Хөрөнгө /тэрбум төгрөг/	2021 /аудитлагдсан/	2022 /аудитлагдсан/	2023 /аудитлагдсан/																																																															
Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө	4.90	5.22	7.89																																																															
Зээлийн багц (цэвэр)	32.43	69.59	123.46																																																															
Бусад хөрөнгө	0.76	1.05	0.51																																																															
Үндсэн хөрөнгө	0.76	0.59	1.25																																																															
Билет бус хоршо	0.45	0.40	0.36																																																															
Нийт хөрөнгө	39.30	76.85	133.47																																																															
Өр төлбөр болон эздийн өмч /тэрбум төгрөг/																																																																		
Өр төлбөр	19.49	52.63	90.74																																																															
Эх үүсвэр	15.07	45.96	79.29																																																															
Хоёрдогч өглөг	2.95	2.95	2.95																																																															
Бусад өглөг	1.47	3.72	8.50																																																															
Эздийн өмчийн дүн	19.81	24.22	42.73																																																															
Хувьцаат капитал	8.48	8.48	8.48																																																															
Хуримтлагдсан ашиг	11.33	15.74	34.25																																																															
Нийт өр төлбөр болон эздийн өмч	39.30	76.85	133.47																																																															
	Орлогын тайлан	<p>Орлого, үр дүнгийн тайлан /Нэгтгэсэн/</p> <table border="1"> <thead> <tr> <th>Орлого, үр дүнгийн тайлан /тэрбум төгрөг/</th> <th>2021 /аудитлагдсан/</th> <th>2022 /аудитлагдсан/</th> <th>2023 /аудитлагдсан/</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Хүүгийн орлого</td> <td>12.49</td> <td>20.22</td> <td>47.84</td> </tr> <tr> <td>Хүүгийн зардал</td> <td>(2.80)</td> <td>(3.95)</td> <td>(9.53)</td> </tr> <tr> <td>Цэвэр орлого</td> <td>9.69</td> <td>16.27</td> <td>38.31</td> </tr> <tr> <td>Зээлийн болзошгүй эрсдэлийн нөөцийн зардал</td> <td>(0.73)</td> <td>(1.44)</td> <td>(2.68)</td> </tr> </tbody> </table>	Орлого, үр дүнгийн тайлан /тэрбум төгрөг/	2021 /аудитлагдсан/	2022 /аудитлагдсан/	2023 /аудитлагдсан/	Хүүгийн орлого	12.49	20.22	47.84	Хүүгийн зардал	(2.80)	(3.95)	(9.53)	Цэвэр орлого	9.69	16.27	38.31	Зээлийн болзошгүй эрсдэлийн нөөцийн зардал	(0.73)	(1.44)	(2.68)																																												
Орлого, үр дүнгийн тайлан /тэрбум төгрөг/	2021 /аудитлагдсан/	2022 /аудитлагдсан/	2023 /аудитлагдсан/																																																															
Хүүгийн орлого	12.49	20.22	47.84																																																															
Хүүгийн зардал	(2.80)	(3.95)	(9.53)																																																															
Цэвэр орлого	9.69	16.27	38.31																																																															
Зээлийн болзошгүй эрсдэлийн нөөцийн зардал	(0.73)	(1.44)	(2.68)																																																															

		Үйл ажиллагааны цэвэр орлого	10.42	14.83	35.63		
		Удирдлагын болон ҮА-ны зардал	(5.95)	(8.29)	(10.26)		
		Татварын өмнөх ашиг	4.47	6.53	25.37		
		Татварын зардал	(0.47)	(1.01)	(5.57)		
		Үндсэн үйл ажиллагааны цэвэр ашиг	4.00	5.53	19.80		
		Татварын дараах алдагдал (Зогсоосон үйл ажиллагаа)	(0.11)	-	-		
		Цэвэр ашиг	3.89	5.53	19.80		
		Өмчийн өөрчлөлтийн тайлан:					
	<i>Өмчийн өөрчлөлтийн тайлан</i>	Өмчийн өөрчлөлтийн тайлан /тэрбум төгрөг/	Хувьцаат капитал	Халаасны хувьцаа	Бусад нөөц	Х.ашиг	Нийт эздийн өмч
		2021.12.31 -ний өдрийн байдлаар	10.76	(2.34)	0.06	11.33	19.81
		Тайлан үеийн цэвэр ашиг				5.52	5.52
		Ногдол ашиг				(1.11)	(1.11)
		2022.12.31 -ний өдрийн байдлаар	10.76	(2.34)	0.06	15.74	24.22

		Тайлан үеийн цэвэр ашиг				19.80	19.80
		Ногдол ашиг				(1.29)	(1.29)
		2023.12.31 -ний өдрийн байдлаар	10.76	(2.34)	0.06	34.25	42.73
		Мөнгөн гүйлгээний тайлан /Нэгтгэсэн/:					
	Мөнгөн гүйлгээний тайлан	Мөнгөн гүйлгээний тайлан /тэрбум төгрөг/	2021 /аудитлагдсан/	2022 /аудитлагдсан/	2023 /аудитлагдсан/		
		Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(0.88)	(28.48)	(27.84)		
		Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	0.98	(0.28)	0.07		
		Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(4.70)	29.08	30.44		
		Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр (бууралт)/ өсөлт	(4.60)	0.32	2.67		

	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	9.50	4.90	5.22
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4.90	5.22	7.89

1.1. *Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт*

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон нэгтгэсэн санхүүгийн тайланд “Шонхор Үнэлгээ Аудит” ХХК нь хөндлөнгийн хараат бус аудитын дүгнэлтийг гаргасан ба уг дүгнэлтийг хавсаргав.

1.2. *Аудитын тодорхойлох захидал /тодорхойлох захидлыг энэхүү зааварт дурдсан агуулгын хүрээнд боловсруулсан байх/*

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон нэгтгэсэн санхүүгийн тайланд “Шонхор Үнэлгээ Аудит” ХХК нь хөндлөнгийн хараат бус аудит хийж, дүгнэлт гаргасан тухай аудитын тодорхойлох захидлыг хавсаргав.

2 *Үнэт цаас гаргагч нь тайлант хүргэцээнд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, удирдлагаас өгсөн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан, мэдээлэл*

2.1. *Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцаа үзүүлэлтүүд/*

2023 оны санхүүгийн үзүүлэлтүүдийг өмнөх 2 жилийн мөн үетэй харьцуулсан байдал:






2023 онд нийт харилцагч нартаа 996.6 тэрбум төгрөгийн дүнтэй 3.3 сая зээлийг LendMN аппликейшнээр дамжуулан олгосон байна. 2023 онд бүртгэлтэй харилцагчдын тоо 1,218.2 мянгад хүрч өмнөх оноос 7.7%-иар өссөн бол, зээлийн багц 76.4%, олгосон зээлийн дүн 77.4% тус тус өссөн үзүүлэлттэй байна. Энэхүү ЛэндМН-ийн зээлийн үйл ажиллагааны өсөлт нь харилцагчдын өсөн нэмэгдэж буй эрэлт хэрэгцээг, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээгээр ханган ажиллаж байгааг илтгэх ба зээлийн багцын дүнгийн үзүүлэлтээр компани үүсэн байгуулагдсанаас хойш хамгийн дээд хэмжээнд хүрч ажилласан байна.





Зээлийн багцын чанарын үзүүлэлт

2023 онд чанаргүй зээлийн багцад эзлэх хувь 4.1%-д хүрч зээлийн эрдэлийн сангийн нооц 5.7 тэрбум төгрөг буюу зээлийн эрдэлийн сангийн хүрэлцээг 109.8%-д хүргэж ажиллалаа.



Зохистой харьцааны тайлан

“ЛэндМН ББСБ” ХК зээлийн эрсдэлийн үнэлгээ, зээлийн үнэ цэнийн бууралтыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт-9 (IFRS-9) дагуу тооцдог. Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “ББСБ-ын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-д заасны дагуу 2023 оны жилийн эцэст 3.1 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн нөөц сан байгуулахаар байсан боловч СТОУС-9 (IFRS-9)-н стандартын дагуу 5.7 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн нөөц санг байгуулсан. Энэ нь Санхүүгийн зохицуулах хорооны дээрх журмаар тооцвол зээлийн эрсдэлийн нөөц санг хангалттай түвшинд буюу нийт чанаргүй зээлийн багцын 109.8% - тай тэнцэх хэмжээнд байгуулжээ. 2023 онд зохицуулагч бийгууллагаяас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж ажилласныг доорх хүснэгтээс харна уу.

2.2. *Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт*

Харьцаа үзүүлэлтүүд	Байвал зохих	2021	2022	2023
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	10%-иас доошгүй	48.6%	28.1%	27.7%
Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнээл нийт активын харьцаа	20%-иас доошгүй	55.5%	31.5%	29.6%
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа	10%-иас доошгүй	50.3%	31.5%	31.6%
Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа	8%-иас дээш	29.4%	12.0%	11.2%
Гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	(+/-40%)	-11.1%	-39.8%	-39.5%
Итгэлцлийн үйлчилгээний өглөг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	80%-иас хэтрэхгүй	33.5%	78.5%	79.7%
Өрийн бичгийн зохистой харьцаа	50%-иас хэтрэхгүй	32.3%	38.0%	26.5%

2.3.	<p>Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл</p>	<ul style="list-style-type: none"> • Санхүүгийн зохицуулах хорооны “Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагааны журам”-ын дагуу Компани нь өөрийн финтек зээлийн бүтээгдэхүүнүүд буюу LendMN аппликейшныг Санхүүгийн зохицуулах хороонд албан ёсоор 2023 оны 06 дугаар сарын 20-ны өдөр бүртгүүлсэн болно. • Мөн Санхүүгийн зохицуулах хорооны Финтек зээлийн бүтээгдэхүүнд өр, орлогын харьцаа тогтоох тухай тушаалыг хэрэгжүүлэн өр, орлогын харьцааг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 70 хувиар тогтоон үйл ажиллагаандаа мөрдөж байна. • 2023 оны II улиралд Flexi шинэ зээлийн бүтээгдэхүүний хөгжүүлэлтийг амжилттай дуусгаж, цөөн тооны зээлдэгчид олгон, туршилтын журмаар хэрэгжүүлсэн байна. “ЛэндМН ББСБ” ХК-ийн зүгээс цаашид үе шаттайгаар харилцагчдад энэхүү бүтээгдэхүүнийг санал болгон ажилласаар байна.
2.4.	<p>Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/</p>	<p>Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээ байхгүй болно.</p>
2.5.	<p>Тайлант хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл;</p>	<p>Тайлант хугацаанд нийт 50.8 тэрбум төгрөгийн зээл, 9 тэрбум төгрөгийн бонд, 31.4 тэрбум төгрөгийн итгэлцлийн санхүүжилтийг татагч төвлөрүүлсэн бөгөөд 59.6 тэрбум төгрөгийн эргэн төлөлт хийгдсэн.</p> <p>Мөн 2023 оны 09 дүгээр сарын 08-ны өдөр 100,000 (Нэг зуун мянган) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий, жилийн 18.0 хувийн хүүтэй, толгой компанийн групп дэх хувьцаагаар барьцаалагдсан 90,000 ширхэг бондыг олон нийтэд гаргасан. Тус бондын хугацаа 2025 оны 09 дүгээр сарын 07-ны өдөр дуусна.</p> <p>2023 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар компани нь арилжааны банкуудаас 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр дуусгавар болох жилийн 12.0 хувийн хүүтэй 1,250 мянган ам.долларын зээлийн шугамтай байсан бөгөөд үүнд 2,500 мянган ам.долларын дансны үнэ бүхий хэвийн зээлийн багцыг барьцаалсан.</p>
3.	<p>Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/</p>	

3.1 Их хэмжээний хэлцэл

Тайлант хугацааны турш их хэмжээний хэлцэл хийгээгүй.

3.2 Сонирхлын зөрчилтэй хэлцэл

2023 онд Компанийн зээлийн үйл ажиллагааны өдрөөс өдөрт өсөн нэмэгдэж буй эрэлтийг хангах, эх үүсвэрийг нэмэгдүүлэх үүднээс холбоотой талаас санхүүжилт хүлээн авах, баталгаа гаргуулахтай холбоотой нийт 6 сонирхлын зөрчилтэй хэлцэлд ЛэндМН-ийн ТУЗ-өөс Монгол Улсын Компанийн тухай хуульд заасан журмын дагуу зөвшөөрөл олгосон байна.

№	Хэлцлийн нөгөө тал	Зөвшөөрөл олгосон огноо	Хэлцэл хийсэн зорилго
1	“АНД Системс” ХХК (Толгой компани)	2023.02.06	“АНД Системс” ХХК-аас үзүүлж буй үйлчилгээний цар хүрээ нэмэгдсэн, цаашдын хамтын ажиллагаа нь Компанийн өсөлт хөгжилтөд эерэг нөлөөтэй болохыг харгалзан, мөн 2020 онтой харьцуулахад инфляцын түвшин нэмэгдсэн зэргийг үндэслэн “АНД Системс” ХХК-тай байгуулсан Менежментийн үйлчилгээний гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах.
2	“АНД Дэнөүд” ХХК болон “АНД Алтернатив Финанс” ХХК (Зэргэлдээ компани)	2023.03.27	Компанийн зээлийн үйл ажиллагаанд шаардлагатай эх үүсвэрийг төвлөрүүлэх зорилгоор “АНД Дэнөүд” ХХК болон “АНД Алтернатив Финанс” ХХК-тай хамтран ажиллаж, тэдний зүгээс итгэлцлээр Компанид шилжүүлсэн хөрөнгийг нь удирдах үйл ажиллагааг явуулах.
3	“АНД Системс” ХХК (Толгой компани)	2023.06.27	Компанийн зүгээс олон нийтэд санал болгох бондын эргэн төлөлтийг баталгаажуулахад барьцаалуулагч талаар “АНД Системс” ХХК-ийг оролцуулах, андеррайтер “Райнос Инвестмент ҮЦК” ХХК болон “АНД Системс” ХХК-тай гурван талт “Хувьцааны барьцааны гэрээ”-г байгуулах.
4	“АНД Системс” ХХК (Толгой компани)	2023.10.19	Компанийн зээлийн шугам нээлгүүлэх зорилгоор “АНД Системс” ХХК-тай байгуулсан “Санхүүжилтийн гэрээ”-нд нэмэлт, өөрчлөлт оруулах
5	“АНД Системс” ХХК (Толгой компани) болон “Тэнгэр Капитал ҮЦК” ХХК	2023.11.09	Компанийн хяалттай хүрээнд санал болгон гаргаж буй бондын эргэн төлөлтийг баталгаажуулах шаардлага үүссэн тул “АНД Системс” ХХК болон “Тэнгэр Капитал ҮЦК” ХХК-тай гурван талт “Хувьцааны барьцааны гэрээ” байгуулах

6	“ОНДО” ХХК	2023.11.09	Компанийн зүгээс цаашид “ОНДО” ХХК-ийн дугаарыг хэрэглэж буй харилцагчид өөрийн үйлчилгээг үзүүлэх, үйлчилгээтэй холбоотой аливаа шаардлагатай мэдээллийг хүргэдэг болох зорилгоор “ОНДО” ХХК-тай “Тусгай дугаараас мессеж илгээх үйлчилгээний гэрээ” байгуулах
---	------------	------------	---

4. Цалин урамшууллын мэдээлэл

ТУЗ-ийн цалин урамшууллын мэдээлэл:

Компанийн ТУЗ-ийн 2023 оны цалингийн хэмжээ, зарцуулах төсвийг 2023 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн Хувьцаа Эзэмшигчдийн Ээлжит Хурал (цаашид “ХЭЭХ” гэх)-аас баталсан ба ТУЗ нь батлагдсан төсвийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа ба нэмэлтээр шагнал, нөхөн олговор, бусад урамшуулал олгоогүй болно.

л/л	Зарллын зүйл	Гишүүдийн тоо	Сарын цалин (төгрөг)	Сар	Нийт төсөв (төгрөг)
1	Цалин урамшууллын төсөв	10	10,600,000	12	143,100,000
1.1	Дарга	1	1,500,000	12	18,000,000
1.2	Хорооны дарга	3	1,200,000	12	43,200,000
1.3	Гишүүн	5	1,000,000	12	60,000,000
1.4	Нарийн бичгийн дарга	1	500,000	12	6,000,000
1.5	НДШ-ийн зардал				15,900,000
2	Хурал болон бусад зардал				10,000,000
	ШИЙТ ТӨСӨВ				153,100,000

Гүйцэтгэх захирлын цалин, шагнал урамшууллын мэдээлэл:

Гүйцэтгэх захирал нь ТУЗ-тэй байгуулсан гэрээний хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Гүйцэтгэх захирлын цалин, шагнал урамшууллын хэмжээг холбогдох хууль тогтоомж, Компанийн ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасны дагуу ЗНДЦУХ-ны хурлаар хэлэлцэн тодорхойлдог бөгөөд шагнал урамшууллын хэмжээг санхүүгийн болон санхүүгийн бус үзүүлэлттэй уялдуулан жил бүр гаргасан гүйцэтгэлийн үнэлгээний шалгуур үзүүлэлтүүдийг үндэслэн Гүйцэтгэх захирлын гэрээнд тусган баталгаажуулдаг.

ЗНДЦУХ-ны зүгээс санхүүгийн жил дуусгавар болсны дараа Гүйцэтгэх захирлын тухайн хугацааны үйл ажиллагаа нь Гүйцэтгэх захирлын гэрээнд туссан санхүүгийн болон санхүүгийн бус үзүүлэлтүүдэд хүрч буй эсэх буюу Компанийн жилийн үйл ажиллагааны нөхцөл байдалтай нэг бүрчлэн харьцуулан тодорхойлж, шагнал урамшуулал олгох эсэхийг ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэх бодлогыг баримталж байна.

Компанийн ТУЗ-ийн 2024 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 24/06 тоот тогтоолоор Гүйцэтгэх захиралд 2023 оны үр дүнгийн урамшуулал олгохоор шийдвэрлээд байна.

5. *Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл*

“ЛэндМН ББСБ” ХК нь Монгол Улсын хууль тогтоомж болон Монголын хөрөнгийн биржийн I ангилалд бүртгэлтэй, нээлттэй хувьцаат компани болохынхоо хувьд Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж, түүнчлэн Монголбанкны холбогдох журам, засаглалын дүрэм, кодексыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

“ЛэндМН ББСБ” ХК нь зохистой засаглал, засаглалын тогтолцоог бэхжүүлэх, үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангахад онцгойлон анхаарч, улмаар удирдлагын баг, төлөөлөн удирдах зөвлөл, хувьцаа эзэмшигчид болон бусад оролцогч талуудын хоорондох цогц харилцааг төгөлдөржүүлэх, засаглалын олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зарчмууд, сайн туршлагыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн урт хугацаанд тогтвортой үнэ цэнийг бий болгохыг үргэлж зорьсоор ирсэн юм.

Компани нь хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчид, харилцагчдын эрх ашгийг хамгаалах, оролцогч талуудтай үр дүнтэй холбоо үүсгэх, санхүүгийн болон санхүүгийн бус мэдээллийг бүрэн бөгөөд үнэн зөв, цаг алдалгүй хүргэх зорилгоор үйл ажиллагааны болон санхүүгийн гүйцэтгэлийн талаар улирал бүрийг болон хагас жилийн хугацааг хамруулан мэдээлэх стратегийг баримталж, нийт 3 удаагийн тайлан гарган олон нийтэд хүргээд байна.

Ийнхүү 2023 оны I улирлын тайланг 2023 оны 05 дугаар сарын 04 ний одор, II улирал буюу хагас жилийн тайланг 2023 оны 07 дугаар сарын 20-ны өдөр, III улирлын тайланг 2023 оны 10 дугаар сарын 28-ны өдөр тус тус гарган олон нийтэд мэдээлснээр Компанийн бизнес, засаглал, санхүүгийн үзүүлэлтүүд болон хэтийн төлөвийн талаарх мэдээллийг тухай бүр авах боломжийг хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчид, харилцагчид болон оролцогч талуудад олгож, харилцан итгэлцэл, эргэх холбоо бүхий хамтын ажиллагааг бий болгосон юм.

Түүнчлэн, Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр болон төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас гарсан тогтоолыг тухай бүр олон нийтэд нээлттэй мэдээлэн ажиллааа

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

“ЛэндМН ББСБ” ХК нь үүсгэн байгуулагдсан цагаасаа эхлэн өнөөдрийг хүртэл санхүү, хөрөнгийн зах зээлд шинийг санаачлагч, манлайлагч байсаар ирсэн уламжлалаа хадгалан компанийн сайн засаглалыг хэрэгжүүлэн цаашид ХЭЭХ-ыг тасалдуулахгүй зохион байгуулан ажиллана.

Компанийн зүгээс Монгол улсын Компанийн тухай хуульд заасны дагуу 2022 оны ХЭЭХ-ыг 2023 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 12:00 цагт Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15-р хороо, Махатма Гандийн гудамж-39, Корпорейт Хотел & Конвейншн центр (Corporate Hotel & Convention Centre)-ийн 2 давхарт байрлах Эвент танхимд зохион байгуулсан ба саналын эрх бүхий хувьцааны 84.36 % буюу 623,709,410 ширхэг хувьцааг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчид оролцсоноор тус хурал хүчин төгөлдөр болсон ба дараах асуудлыг хэлэлцэн баталсан юм. Үүнд:

- Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайланг танилцуулах;
- Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэн батлах;
- Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны тайланг танилцуулах;
- Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг улируулан сонгох;
- Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2023 оны төсвийг батлах;
- Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ (ЦААШИД “ТУЗ”)-ИЙН ХУРАЛ, ТҮҮНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

ТУЗ нь Компанийн үйл ажиллагааг бэхжүүлэх, зохистой түвшинд удирдах, засаглалын олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зарчмууд, сайн туршлагыг хэрэгжүүлэх, стратегийн зорилтдоо хүрэхэд Компанийг ерөнхий удирдлагаар хангаж, хяналт тавихыг эзрэгцрээ Гүйцэтгэх удирдлагад компанийн үйл ажиллагааг үр ашигтай, үр дүнтэй удирдахад нь шаардлагатай чиглэлийг өгч ажилладаг.

Компанийн ТУЗ нь срдийн 6, хараат бус 3 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр тогтмол үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд өнгөрсөн нэг жилийн хугацаанд 5 удаа ээлжит, 7 удаа ээлжит бусаар хуралдан нийт 35 тогтоол гаргажээ. ТУЗ-ийн бүхий л тогтоолуудыг холбогдох журамд заасны дагуу Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлээд байна.

ТУЗ-ийг эрх, үүргээ бүрэн хэрэгжүүлж, үйл ажиллагаагаа үр дүнтэй явуулах зорилгын хүрээнд Компанийн дүрэм, ТУЗ-ийн Үйл ажиллагааны журмаар тодорхойлсон, тодорхой чиг үүрэг, байнгын ажиллагаа бүхий 1/ Эрсдэлийн удирдлагын хороо, 2/ Аудитын хороо, 3/ Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороод үйл ажиллагаа явуулж байна.

ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООДЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Эрсдэлийн удирдлагын хороо (цаашид “ЭУХ”)

ЭУХ нь тайлант жилийн хугацаанд нийт 5 удаа хуралдаж, Компанийн бизнесийн хөгжил, эрсдэл болон эх үүсвэрийн үйл ажиллагааны бодлогыг тодорхойлох, учирч болзошгүй эрсдэлийг оновчтой удирдан чиглүүлэхэд дэмжлэг үзүүлэх, нөхцөл байдалтай тухай бүр танилцан хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлэн ажилласан байна.

ЭУХ-ны бүрэлдэхүүн: ЭУХ-ны даргаар ТУЗ-ийн гишүүн Б.Итгэл, гишүүдээр С.Энх-Амгалан, В.Баярсайхан, Д.Галхүү, Ц.Ууганбаяр, Б.Хос-Эрдэнэ нар ажиллаж байна.

Аудитын хороо

Аудитын хороо нь тайлант жилийн хугацаанд нийт 5 удаа хуралдаж, Компанийн дотоод хяналтын тогтолцооны хэрэгжилтэд хяналт тавьж, дотоод аудиторын үйл ажиллагааны тайлантай тухай бүр танилцан шаардлагатай санал, зөвлөмжийг холбогдох албан тушаалтнууд болон Компанийн газар, албадад өгч ажиллалаа. Түүнчлэн, Компанийн зүгээс хийсэн сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаар дүгнэлт гаргах, Компанийн санхүүгийн тайланг баталгаажуулах хөндлөнгийн аудитын байгууллагыг томилох, Компанийн үйл ажиллагаа

нээлттэй, ил тод байлгахад анхаарч мэдээллийг тухай бүр олон нийтэд хүргэж буй эсэхэд хяналт тавьж ажилласан байна.

Аудитын хорооны бүрэлдэхүүн: Аудитын хорооны даргаар ТУЗ-ийн хараат бус гишүүн Ж.Жаргалсүрэн, гишүүдээр О.Болдбаатар, ТУЗ-ийн хараат бус гишүүн С.Боргил нар ажиллаж байна.

Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороо (цаашид “ЗНДЦУХ”)

ЗНДЦУХ нь тайлант жилийн хугацаанд нийт 3 удаа хуралдаж, ТУЗ-ийн гишүүдийг улируулан сонгох, ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг шинээр сонгох асуудлыг хэлэлцэн Компанийн ХЭЭХ-д танилцуулан шийдвэрлүүлэх тухай шийдвэрлэж, мөн Компанийн мөрдөж буй ажлын үр дүнтэй холбоотой урамшууллын системийн хэрэгжилттэй холбоотой зөвлөмжийг холбогдох албан тушаалтнуудад өгч, гүйцэтгэх захирлын томилгоо, гүйцэтгэх захирлын урамшуулалтай холбоотой дүгнэлт гарган ажилласан байна.

ЗНДЦУХ-ны бүрэлдэхүүн: ЗНДЦУХ-ны даргаар С.Энх-Амгалан, гишүүдээр ТУЗ-ийн хараат бус гишүүн С.Боргил, Д.Галхүү нар ажиллаж байна.

ТУЗ-ийн гишүүдийн ирц, ажилласан хугацааны мэдээлэл:

д/д	ТУЗ-ийн гишүүдийн нэрс	2023 оны ТУЗ-ийн хурлын ирц	ТУЗ-д ажилласан хугацаа, туршлага	Компанид хувьцаа эзэмшдэг эсэх
1	О.Болдбаатар	100%	ХЭЭХ-аас тухай бүр сонгогдож, 6 дахь жилдээ ажиллаж байна.	37,097 ширхэг хувьцаа буюу Компанийн нийт хувьцааны 0.0046%
2	С.Энх-Амгалан	91.7%	ХЭЭХ-аас тухай бүр сонгогдож, 6 дахь жилдээ ажиллаж байна	Үгүй
3	В.Баярсайхан	91.7%	ХЭЭХ-аас тухай бүр сонгогдож, 6 дахь жилдээ ажиллаж байна	Үгүй
4	Б.Итгэл	91.7%	ХЭЭХ-аас сонгогдож, 2 дахь жилдээ ажиллаж байна	520 ширхэг хувьцаа буюу Компанийн нийт хувьцааны 0.0001%
5	Б.Хос-Эрдэнэ	100%	ХЭЭХ-аас сонгогдож, 2 дахь жилдээ ажиллаж байна	Үгүй
6	Ц.Ууганбаяр	100%	ХЭЭХ-аас сонгогдож, 2 дахь жилдээ ажиллаж байна	18,016 ширхэг хувьцаа буюу Компанийн нийт хувьцааны 0.0023%
7	Ж.Жаргалсүрэн	91.7%	ХЭЭХ-аас тухай бүр сонгогдож, 6 дахь жилдээ хараат бус гишүүнээр ажиллаж байна	Үгүй

8	С.Боргил	100%	ХЭЭХ-аас тухай бүр сонгогдож, 6 дахь жилдээ хараат бус гишүүнээр ажиллаж байна	7,076 ширхэг хувьцаа буюу Компанийн нийт хувьцааны 0.0009%
9	Д.Галхүү	100%	ХЭЭХ-аас сонгогдож, 2 дахь жилдээ хараат бус гишүүнээр ажиллаж байна	Үгүй

Компанийн ТУЗ-ийн гишүүд нь Монгол Улсын Компанийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын Хөрөнгийн биржийн холбогдох журам, кодекс, түүнчлэн Компанийн дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэн ажилладаг бөгөөд аливаа шийдвэрийг хараат бусаар, бие даан гаргадаг. ТУЗ-ийн аливаа шийдвэр нь олонхын саналаар хүчин төгөлдөр болдог ба ТУЗ-ийн гишүүн нь хэлэлцэж буй асуудлаар “дэмжсэн”, “татгалзсан”, “гүдгэлзсэн” санал гаргах боломжтой. ТУЗ-ийн гишүүд нь тайлант хугацаанд чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж, хичээл зүтгэл гарган ажилласан гэдгийг ТУЗ-ийн хурлын ирцээс харж болох бөгөөд Компанийн үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардлагатай, ач холбогдолтой шийдвэрүүдийг холбогдох баримт бичиг, судалгаа, тайлбар дүгнэлттэй нэг бүрчлэн танилцсаны үндсэн дээр цаг алдалгүй гаргаж, Компанийн 2023 оны амжилтын голлох хүчин зүйлсийн нэг болсон юм.

ТУЗ-ИЙН ХУРЛЫН ТОГТООЛ, ТӨРӨЛ БОЛОН БУСАД МЭДЭЭЛЭЛ

д/д	Шийдвэр гаргасан огноо	Ирц	Шийдвэр гаргасан хэлбэр	Баталсан тогтоолын тоо
1	2023 оны 01 дүгээр сарын 25	100%	Эчнээ санал хураалт	4
2	2023 оны 02 дугаар сарын 06	100%	Ээлжит хурал	9
3	2022 оны 03 дугаар сарын 03	100%	Эчнээ санал хураалт	2
4	2022 оны 03 дугаар сарын 27	100%	Эчнээ санал хураалт	1
5	2023 оны 05 дугаар сарын 24	77.8%	Ээлжит хурал	3
6	2023 оны 06 дугаар сарын 27	100%	Эчнээ санал хураалт	2
7	2023 оны 07 дугаар сарын 21	88.9%	Эчнээ санал хураалт	1
8	2023 оны 08 дугаар сарын 03	88.9%	Ээлжит хурал	2
9	2023 оны 10 дугаар сарын 19	100%	Ээлжит хурал	2
10	2023 оны 11 дүгээр сарын 09	100%	Эчнээ санал хураалт	3
11	2023 оны 11 дүгээр сарын 13	100%	Эчнээ санал хураалт	1
12	2023 оны 12 дугаар сарын 22	88.9%	Ээлжит хурал	5

Удирдлага зохион байгуулалт	Санхүү	Эрх олгох	Үйл ажиллагаа	Бизнес стратеги
16	6	6	5	2

“КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ЫН ХЭРЭГЖИЛТ, ТҮҮНИЙ ҮНЭЛГЭЭ

Компани нь Санхүүгийн Зохицуулах Хорооны 2022 оны 03 дугаар сарын 23-ний өдрийн 145 тоот тогтоолоор шинэчлэгдэн батлагдсан “Компанийн засаглалын кодекс”-ыг үйл ажиллагаандаа даган мөрдөж, 2023 оны 11 дүгээр сарын байдлаар 98.6%-ийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлэн ажилласан байна. Түүнчлэн, “Компанийн засаглалын кодекс” нь тасралтгүй хэрэгжиж, үйл ажиллагааны онцлогоос хамаарч үнэлгээ нь тухай бүр шинэчлэгддэг онцлогтой тул Компанийн зүгээс 100%-ийн гүйцэтгэлд хүрэхийн тулд хүчин зүтгэл гарган ажиллах болно.

№	Үндсэн зарчим	Авбал зохих нийт оноо	Хяналтын оноо	Үнэлгээний хувь
1	ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12	11	91.6 %
2	ТУЗ-ийн дэргэдэх хороод, гэдгээрийн чиг үүрэг	10	10	100%
3	Тайлагнал, мэдээллийн ил тод, байдал	6	6	100%
4	Аудит, хяналтын тогтолцоо	6	6	100%
5	Эрсдэлийн удирдлага	8	8	100%
6	Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал	6	6	100%
7	Оролцогч талуудын эрх ашиг	8	8	100%
8	Компанийн соёл	6	6	100%
9	Хувьцаа эзэмшигчдийн эрх	10	10	100%
	Нэгдсэн дүн	72	71	98.6%

БУСАД ТАЙЛАН, МЭДЭЭЛЭЛ

2023 оны байдлаар дараах тайлан, мэдээллүүдийг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хугацаанд илгээж, олон нийтэд мэдээлсэн байна. Үүнд:

- 2022 оны жилийн санхүү болон үйл ажиллагааны тайлан;
- 2022 оны аудитлагдсан санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт;
- 2023 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын шийдвэр, тэмдэглэл холбогдох баримт бичгүүд;
- 2023 оны I улирлын үйл ажиллагааны тайлан;
- 2023 оны хагас жилийн тайлан;
- 2023 оны III улирлын үйл ажиллагааны тайлан;
- 2023 онд ТУЗ-өөс гарсан тогтоолууд;
- Компанийн бүтээгдэхүүн, үйл ажиллагаатай холбоотой цаг үеийн мэдээллүүд.

Түүнчлэн тайлагнал, мэдээллийн ил тод байдлыг хангах зорилгоор Компанийн социал сувгууд болон харилцагчийн үйлчилгээний төвийн 77070101 тоот утсаар харилцагч, хувьцаа

эзэмшигч, хөрөнгө оруулагчдын санал, хүсэлт, асуултад тухай бүр хариу өгч, мэдээлэл солилцон ажилласан байна.

Санхүүгийн Зохицуулах Хорооноос 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдөр Новотел зочид буудалд зохион байгуулсан “КОМПАЕНСЫН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ” сэдэвт хэлэлцүүлэгт “ЛэндМН ББСБ” ХК оролцлоо. Нээлттэй хувьцаат компаниуд, зохицуулалтай этгээд болон судлаачдын төлөөлөл оролцсон уг хэлэлцүүлгийн “Компанийн засаглалын кодексын хэрэгжилт” хэсэгт ЛэндМН-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Б.Итгэл панелистаар оролцож, ЛэндМН-ийн “Компанийн засаглалын кодекс”-ыг амжилттай хэрэгжүүлж буй туршлага, сайн засаглалын хүрээнд хуримтлуулсан мэдлэгээсээ хуваалцав.

6. *Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл*

“ЛэндМН ББСБ” ХК нь Монголын Хөрөнгийн Биржид бүртгэлтэй нээлттэй компанийн хувьд хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч, харилцагчид болон хамтран ажиллагч нарынхаа итгэлийг хүлээж бизнесийн ёс зүйг эрхэмлэн ажиллаж, сайн засаглалын хүрээнд Эрсдэлийн удирдлагын үр дүнтэй тогтолцоог бүрдүүлж ажилласаар ирлээ.

Эрсдэлийн удирдлагын тогтолцоо нь Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс баталсан Эрсдэлийн удирдлагын бодлогоор “Гурван шугамын загвар”-ыг дараах байдлаар тодорхойлон компанийн бүх нэгжүүдийн чиг үүрэг, төлөвлөгөө, гүйцэтгэлийн үнэлгээг уялдуулан ажиллаж байна.

I шугам	II шугам	III шугам
Компанийн бодлого, журам болон өөрсдийн чиг үүргийн хүрээнд өдөр тутмын бизнесийн үйл ажиллагааныхаа эрсдэлийг хариуцан ажиглалт бизнес нэгжүүд болон тэдгээрийг Дэмжих чиг үүрэгтэй нэгжүүд	“Нэгдүгээр шугам”-д хамаарах Нэгжүүдийн эрсдэлээ хэрхэн Удирдаж байгаад хяналт тавих, компанийн хэмжээнд ямар хэмжээний эрсдэл хүлээж байгааг хянах, хязгаарлах чиг Үүрэгтэй нэгжүүд	Хараат бус дотоод аудитын чиг үүрэг бүхий I нэгж

Эрсдэл хянан нийцүүлэлтийн нэгж нь Финтек зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээ харилцагчид хүргэх арга, хэлбэрээс хамаарч үүсэх эрсдэл, харилцагчаас хамаарч үүсэх эрсдэлийг тус тус үнэлж түүнийг бууруулах зөвлөмж хүргүүлж, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан үе шаттайгаар тогтмол хэрэгжүүлэн ажилласан ба 2023 оны онцлох үйл явдал болох Финтек зээлийн үйлчилгээний эрх зүйн орчин бүрдсэнтэй холбоотойгоор Санхүүгийн Зохицуулах хорооны “Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагааны журам”-ын шаардлагыг бүрэн хангаж Финтек зээлийн бүтээгдэхүүнээр бүртгэгдсэн.

"Зээлийн эрсдэлийн удирдлага"

Зээлийн эрсдэл гэдэг нь зээлдэгч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйн улмаас ББСБ алдагдал хүлээх магадлалыг хэлнэ. “ЛэндМН ББСБ” ХК нь зээлийн эрсдэлийн удирдлага нь

эрсдэлийн тодорхой орчин нөхцөлд тохируулан эрсдэлийн нөлөөллийг удирдах замаар компанийн ашигт ажиллагаа, өгөөжийг хамгийн өндөр түвшинд байлгахад чиглэдэг.

Санхүүгийн байгууллагуудын өр, өөрийн хөрөнгийн харьцаа 1.5-аас 3.0-ын хооронд байх нь хэвийн гэж үздэг. Өөрийн хөрөнгө нэмэгдсэнээр ББСБ-ын зээлжих чадвар сайжирч, санхүүжилтийн эх үүсвэрийн өртгийг багасгадаг. 2023 онд “ЛэндМН”-ийн нийт олгосон зээл 2 дахин өссөн төдийгүй өөрийн хөрөнгө хамгийн ихээр буюу 65%-иар өссөн тус харьцаа хамгийн бага байгаа нь төлбөрийн чадваргүй болох эрсдэл багатайг илтгэж байна.

"Комплаенсийн эрсдэл"

Комплаенсийн эрсдэлийн хүрээнд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааг бодлогын түвшинд, компанийн хэмжээнд удирдах, хянах үндсэн чиг үүрэгтэй ажиллаж байна. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулиар хүлээсэн үүргийнхээ хүрээнд Харилцагчийг таньж мэдэх, эрсдэлийг үнэлэх, хяналт тавих арга хэмжээг тогтмол үйл ажиллагаандаа хэрэгжүүлж урьдчилан сэргийлэх арга хэмжээг тогтмол авч ажилласан бөгөөд Монгол улсын хэмжээнд шинэчлэгдсэн, нэмэлт өөрчлөлт орсон хууль тогтоомж, Зохицуулагч байгууллагын дүрэм журамд орсон өөрчлөлтийг тухай бүр өөрийн компанийн дотоод бодлого, журамд нийцүүлэн холбогдох өөрчлөлтийг оруулан өдөр бүр үйл ажиллагаандаа нийцүүлэн ажиллалаа.

Комплаенсийн эрсдэлийн удирдлагын хүрээнд “Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны дотоод хяналт болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөр”, Санхүүгийн зохицуулах хорооны 160 тоот тогтоолоор баталсан “Банк бус санхүүгийн байгууллагын зээлийн үйл ажиллагааны журам” батлагдсантай холбоотой “Зээлийн үйл ажиллагааны журам”-г болон “Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын журам”, “Хөдөлмөрийн дотоод журам”, “Нууцлалын журам”, “Мэдээлэл технологийн дэд бүтцийн журам”, “Харилцагчийг таньж мэдэх, төлбөр тооцооны эрсдэлийн үнэлгээ хийх, эрсдэлд хяналт тавих үйл ажиллагааны журам”, “Биет бус мэдээллийг нөөцлөх, нөхөн сэргээх журам” болон бусад журмыг тухай бүр шинэчлэн үйл ажиллагаандаа нийцүүлэн баталж ажилласан байна.

ЛэндМН-ийн голлох эрсдэлүүд:

Гол эрсдэлүүд	Эрсдэлийн үйл явдал, үр дагавар, нөлөөлөл	Эрсдэлийн удирдлагын хэрэгжилт
Зах зээлийн эрсдэл	- Гадаад валютын ханшийн өөрчлөлтөөр санхүүгийн алдагдал хүлээх, - Эх үүсвэр болон активын хүүгийн зөрүүгээс санхүүгийн алдагдал хүлээх.	- Гадаад валютын нээлттэй цэвэрлэлийг зохистой түвшинд барин ажиглав - Эх үүсвэр, активын удирдлагыг оновчтой хэрэгжүүлсэн. - Гадаад валют, үнэт цаасны ханшийн хэлбэлзлийг тооцон ажиллав.
Санхүүгийн эрсдэл	- Зохистой харьцааны үзүүлэлт алдагдах.	- Төлөвлөлт хангалттай хэрэгжүүлсэн. - Тогтмол тайлагналт хийж байв.

	<ul style="list-style-type: none"> - Төлбөрийн чадвар алдагдах буюу хөрөнгө оруулагчийн мөнгөн хөрөнгийг анхны шаардлагаар буцаан төлөх боломжгүй болох. - Зээлийн эрэлт, өсөлтийг хангахгүй болох. - Өөрийн хөрөнгийн хүрэлцээний зохистой харьцаа үзүүлэлт алдагдах. 	<ul style="list-style-type: none"> - Дотоод хяналтыг хэрэгжүүлсэн. - Эх үүсвэрийн төвлөрлийг удирдсан. - Хөрөнгийн зах зээлийн нөхцөл байдалтай уялдуулсан бодлого чиглэл баримталж ажиллалаа.
Зээлийн эрсдэл	<ul style="list-style-type: none"> - Зээлийн багцын чанар буурах. - Зээл төлөгдөхгүй байх магадлал (PD) болон зээлийн алдагдал үүсэх (LGD) магадлал нэмэгдэх. - Зээлийн болзошгүй эрсдэлийн сангийн хэмжээ өсөх. 	<ul style="list-style-type: none"> - Компанийн дотоод бодлого, журам, бүтээгдэхүүний нөхцөлийг шинэчлэн баталлаа. - Зээлийн скоринг, зээлдэгчийн үнэлгээний загвар, аргачлалыг дахин шинэчлэв.
Үйл ажиллагааны эрсдэл	<ul style="list-style-type: none"> - Биет эд хөрөнгийн зардал. - Бизнесийн үйл ажиллагааны тасалдал. - Санхүүгийн хохирол (мөнгөн алдагдал). - Санхүүгийн бус хохирол (мөнгөн дүнгээр хэмжих боломжгүй нэр хүндийн гэм). 	<ul style="list-style-type: none"> - Дотоод бодлого, журам, зааврыг шинэчлэв. - Дотоод хяналтын хэрэгжилтийг ханган ажиллалаа. - Компанийн үйл ажиллагаанд нөлөөлөхүйц гадаад, дотоод эрсдэлийг үнэллээ.
Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэл	<ul style="list-style-type: none"> - Мэдээлэл алдагдах, түүнийг буруугаар ашиглах. - Мэдээллийн бааз гэмтэх, устгах. Мэдээлэлд хандах боломжгүй болох. Системийн эмзэг байдлыг ашиглах. 	<ul style="list-style-type: none"> - ISO 27001:2013 мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцооны стандартыг нэвтрүүлэн ажиллалаа. - Мэдээллийн аюулгүй байдлын бодлогыг хэрэгжүүлж, түүнтэй холбоотой журмуудыг шинэчлэн баталлаа. - Системийн эмзэг байдал, цахим халдлага зэрэг эрсдэлээс урьдчилан сэргийлж тогтмол аюулгүй байдлын тест явуулж ажиллалаа.
Байгаль орчин, нийгмийн хариуцлага	<ul style="list-style-type: none"> - Финтек чиглэлээр санхүүгийн үйлчилгээ зөвхөн иргэдэд үзүүлдэг. Тус үйл ажиллагааг явуулахад байгаль орчинд нөлөөлөх эрсдэл бусад салбартай харьцуулбал харьцангуй бага тул байгальд ээлтэй үйл ажиллагаа явуулдаг гэж хэлж болно. 	<ul style="list-style-type: none"> - Шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ гаргахдаа хууль, хянан нийцүүлэлт болон байгаль орчин нийгэмд эрсдэлтэй эсэхийг харгалзан үзэж шийдвэр гаргадаг. - Байгаль орчинд ээлтэй эко автомашины зээл гаргав.

7.	<i>Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл /5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс эзэмшлийн хувь, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо/</i>																				
<table border="1"> <thead> <tr> <th data-bbox="287 264 335 369">№</th> <th data-bbox="343 264 782 369">Хувьцаа эзэмшигч</th> <th data-bbox="790 264 1197 369">Эзэмшиж буй хувьцааны тоо (ширхэг)</th> <th data-bbox="1204 264 1460 369">Эзэмшлийн хувь</th> </tr> </thead> <tbody> <tr> <td data-bbox="287 380 335 459">1</td> <td data-bbox="343 380 782 459">“АНД Системс” ХХК</td> <td data-bbox="790 380 1197 459">600,000,000</td> <td data-bbox="1204 380 1460 459">75%</td> </tr> <tr> <td data-bbox="287 470 335 548">2</td> <td data-bbox="343 470 782 548">Олон нийт</td> <td data-bbox="790 470 1197 548">139,301,683</td> <td data-bbox="1204 470 1460 548">17.41%</td> </tr> <tr> <td data-bbox="287 560 335 638"></td> <td data-bbox="343 560 782 638">Халаасны хувьцаа</td> <td data-bbox="790 560 1197 638">60,698,317</td> <td data-bbox="1204 560 1460 638">7.58%</td> </tr> <tr> <td data-bbox="287 649 335 705"></td> <td data-bbox="343 649 782 705">Нийт</td> <td data-bbox="790 649 1197 705">800,000,000</td> <td data-bbox="1204 649 1460 705">100%</td> </tr> </tbody> </table>	№	Хувьцаа эзэмшигч	Эзэмшиж буй хувьцааны тоо (ширхэг)	Эзэмшлийн хувь	1	“АНД Системс” ХХК	600,000,000	75%	2	Олон нийт	139,301,683	17.41%		Халаасны хувьцаа	60,698,317	7.58%		Нийт	800,000,000	100%	<p>2023 онд: Нийт арилжаалагдсан ширхэг - 25.2 сая ширхэг Нийт арилжаалагдсан үнийн дүн - 1.056.0 сая тогрөг IPO хийснээс хойш нийт 321.1 сая ширхэг, 15.7 тэрбум төгрөгийн хувьцаа арилжаалагдсан. Хувьцаа эзэмшигчдийн тоо: 7000 гаруй.</p> <p>Тайлант хугацаанд компани эргүүлэн худалдан авсан халаасны хувьцаа байхгүй ба ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх, урамшуулах хөтөлбөр хэрэгжүүлээгүй болно. 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар компанийн халаасны хувьцаа 60,698,317 ширхэг байна.</p>
№	Хувьцаа эзэмшигч	Эзэмшиж буй хувьцааны тоо (ширхэг)	Эзэмшлийн хувь																		
1	“АНД Системс” ХХК	600,000,000	75%																		
2	Олон нийт	139,301,683	17.41%																		
	Халаасны хувьцаа	60,698,317	7.58%																		
	Нийт	800,000,000	100%																		
8.	<i>Үнэт цаас сарсагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжилж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл</i>																				
	“ЛэндМН ББСБ” ХК нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргаагүй.																				
9.	<i>Ногдол ашгийн мэдээлэл</i>																				
	<p>“ЛэндМН ББСБ” ХК-ийн Ногдол ашгийн бодлогын дагуу 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн ТУЗ-ийн хурлын 23/09 тоот тогтоолоор “ЛэндМН ББСБ” ХК-ийн 2022 оны цэвэр ашгийн 23.4%-ийг буюу нэгж хувьцаанд 1.75 төгрөг, нийт 1,293,778,000 (Нэг тэрбум хоёр зуун ерэн гурван сая долоон зуун далан найман мянган) төгрөгийн ногдол ашгийг хуваарилахаар шийдвэрлэсэн бөгөөд ЛэндМН-ийн зүгээс 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр “Үнэт Цасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв” ХХК-аар дамжуулан ногдол ашгийг шилжүүлсэн билээ.</p> <p>Мөн 2024 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн ТУЗ-ийн хурлын 24/03 тоот тогтоолоор “ЛэндМН ББСБ” ХК-ийн 2023 оны цэвэр ашгийн 29.9%-ийг буюу нэгж хувьцаанд 8 (Найман) төгрөг буюу нийт 5,914,413,464 (Таван тэрбум есөн зуун арван дөрвөн сая дөрвөн зуун арван гурван мянга дөрвөн зуун жаран дөрвөн) төгрөгийн ногдол ашгийг хуваарилахаар шийдвэрлэлээ.</p>																				



2023 оны ногдол ашгийг 2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр “Үнэт цаасны төлбөр тооцооны төвлөрсөн хадгаламжийн төв” ТӨХК-аар дамжуулан хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулан олгоно.

10

Үнэт цаас гаргагчаас тайлант хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлангийн мэдээлэл

- ЛэндМН нь нийгмийн хариуцлагынхаа хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ Үүнд:
- Ногоон ирээдүй, экологийн тэнцвэрт байдлыг хадгалах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгод ажлуудад идэвх чармайлттай жил бүр оролцоор ирсэн бөгөөд “Минж үржүүлэх, нутагшуулах төв”-д байрлах “Цэцэрлэгт хүрээлэн”-д 2023 оны 05 дугаар сарын 13-ны өдөр Монголын Банк Бус Санхүүгийн Байгууллагуудын Холбоонооны Удирдах Зөвлөл, Санхүүгийн зохицуулах хороо, Гишүүн байгууллагуудтай хамтран 4 төрлийн 640 мод тарилаа.
 - “Мод тарих үндэсний өдөр”-ийг тохиолдуулан Санхүүгийн Зохицуулах Хорооноос өрнүүлсэн санаачилга, уриалгыг дэмжин 2023 оны 05 дугаар сарын 14-ний өдөр Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хороонд байрлах “Инчьеон мөрөөдлийн төгөл”-д мод тарилаа. Энэхүү үйл ажиллагаанд Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж, Монголын Ипотекийн корпораци ОССК, Үнэт цаасны төрөлжсөн хадгаламжийн төв, Монголын үнэт цаасны клирингийн төв тэргүүтэй нийт 20 гаруй байгууллагын хамт олон оролцож 1,100 гаруй мод хамтран тарьж, усалгааг хийж нэрэмжит төглийг бий болголоо.
 - Монголын Банк Бус Санхүүгийн Байгууллагуудын Холбооноос “Цус сэлбэлт судлалын үндэсний төв”-тэй хамтран жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Амьдрал бэлэглэе” цусаа хандивлах аяныг 5 дахь жилдээ 2023 оны 9 дүгээр сарын 13, 14-ний өдрүүдэд зохион байгуулж, тус аянд оролцсон 4 жилийн хугацаанд Холбооны гишүүн 71 ББСВ-ын 910 ажилтан, албан хаагчид оролцож 3,000 хүнд амьдрал бэлэглэжээ. “Амьдрал бэлэглэе” цусаа хандивлах аянд ЛэндМН-ийн залуус ч жил бүр идэвхтэй оролцож, энэхүү их үйлсэд өөрсдийн хувь нэмрээ орууллаа.
 - ЛэндМН нь MENTOR HUB -тай хамтран хүүхдийн баярыг угтан ирээдүйн эзэд болсон 13-18 насны өсвөр насны хүүхдүүдэд мэргэжлээ зөв сонгох, санхүүгээ хэрхэн зөв удирдахад

зориулсан “САЙН УУ, ИРЭЭДҮЙ МИНЬ” эвентийн “ЕРӨНХИЙ ИВЭЭН ТЭТГЭГЧ”-ээр ажиллалаа. Эвентийг зорин ирсэн хүүхдүүдэд Лэндийн ах, эгч нараас нь гарын бэлэг өгснөөс гадна, Lend Plus-Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүнийг танилцуулан мэдээлэл хүргэж санхүүгийн мэдлэгт нь хувь нэмрээ оруулахыг зорин ажиллалаа. Мөн “Монголын Банк Бус Санхүүгийн Байгууллагуудын Холбоо”-той хамтран “Бид санхүүч гэр бүл” сэдэвт хүүхдийн гар зургийн уралдааныг амжилттай зохион байгуулж, ирүүлсэн нийт 116 бүтээлүүдээр “ЛэндМН ББСБ” ХК-ийн Харилцагчийн үйлчилгээний төвд ҮЗЭСГЭЛЭН гаргаж, 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдөр гар зургийн уралдаанд ирүүлсэн бүтээлүүдийг мэргэжлийн зураач шүүгчдийн багаар дүгнүүлж, уран сэтгэмж, зурах техник, бүтээлч байдлыг харгалзан үзэж 9 хүүхдийн бүтээлийг шилдгээр шалгаруулав. Шилдгээр шалгарсан болон уралдаанд оролцсон бүх хүүхдүүдээ ЛэндМН-ийн ах эгч нараас нь хүүхдийн баярын бэлэг гардуулж, хүүхдийн инээд бялхсан сайхан үйл ажиллагаа болж өнгөрлөө.

- Харилцагчийн үйлчилгээний төв нь хэрэглэгчдэд шаардлагатай тусламж үйлчилгээг үзүүлэн 2023 онд нийт 285,063 дуудлага хүлээн авч, сошиал суваг болон үйлчилгээний заалаар ламжуулан 99,350 хэрэглэгчдэд үйлчлэн ажилласан байна. Нэг хэрэглэгч зээл авахад хамгийн багадаа 3 цаг зарцуулдаг гэж үзвэл бид цахимаар хамгийн шуурхай зээлийн үйлчилгээг үзүүлснээр 204.6 мянган харилцагчийн зээл авахад зарцуулах 614 мянган цаг буюу 70 жилтэй тэнцэх хэмжээний хугацааг хэмнэх боломжийг олгожээ. Нэг удаагийн зээл олголтод дунджаар 15 хуудас цаас зарцуулдаг. Бид 3.3 сая удаагийн зээлийг цахим хэлбэрээр баримт бүрдүүлэхгүй олгосноор 130 тонн цаас хэмнэж 3,056 ширхэг мод аварчээ.

Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Ц.Ууганбаяр

Албан тушаал: “ЛэндМН ББСБ” ХК-ийн гүйцэтгэх захирал

Гарын үсэг:

(Тамга/тэмдэг)



/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 378 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/

Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Б.Оюунболд

Албан тушаал: ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга

Гарын үсэг:

Огноо: 2024 оны 02 дугаар сарын 22-ны өдөр



“ЛэндМН ББСБ” ХК-ийн
хувьцаа эзэмшигчдэд

“ШОНХОР ҮНЭЛГЭЭ АУДИТ” ХХК

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
6 дугаар хороо, Метро бизнес оффис,
6 дугаар давхар 603 тоот

Утас: 70150001, 80110088

Цахим хаяг: www.shonkhor.mn

И-мэйл: shonkhor.mn@gmail.com

2024.01.29 № 24/9

танай _____ -ны № _____ -г

Аудитын гэрээт ажлын захидал

Таны энэ өдрийн амар амгаланг айлтгая

“ЛэндМН ББСБ” ХК-ийн 2023.12.31-нээрх тасалбар болгосон санхүүгийн зэрэгцүүлсэн мэдээлэлд аудит хийлгэх тухай хүсэлтийг хүлээн авч байгаагаа илэрхийлэн, дор дурдсан зарчмын зүйлүүдийг энэхүү захидлаар Та бүхний сонорт хүргэхийг хүсч байна. Энэхүү гэрээт ажил нь юуны өмнө танай компанийн 2023.12.31 нээрх тасалбар болгосон санхүүгийн тайланг Монгол улсын хууль, Санхүүгийн тайлангийн олон улсын стандартын дагуу шалгаж, үнэлэх зорилготой. Бид гүйцэтгэсэн ажлынхаа үр дүнд үндэслэн танай санхүүгийн тайлангийн талаар аудиторын тайлан, дүгнэлт гаргах буюу мэргэжлийн саналаа илэрхийлэх үүрэгтэй.

Санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын болон Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартуудын зарчмуудад нийцүүлэн бэлтгэж танилцуулах нь танай байгууллагын удирдлагын хүлээх үүрэг хариуцлага болно. Энэхүү үүрэг хариуцлагад санхүүгийн тайлангуудыг үнэн бодитойгоор бэлтгэх, дотоод хяналт, нягтлан бодох бүртгэлийн бодлогуудыг сонгож хэрэглэх, эдгээрийн үр дүнг нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланд шударгаар толилуулах зэрэг үүргүүд багтана.

Өмч хөрөнгийн аюулгүй байдлыг хангаж, үр нөлөө бүхий нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтыг хууль стандартын дагуу тогтмол үр дүнтэй ажиллуулах нь удирдлагын хууль ёсны үүрэг байдаг.

Санхүүгийн тайлангийн аудитыг Нягтлан Бодогчдын Олон Улсын Холбоо /IFAC/-ны Аудит Баталгаажуулалтын Олон Улсын Стандартын Зөвлөлөөс батлан гаргасан Аудитын Олон Улсын Стандарт /АОУС/-ын дагуу гүйцэтгэнэ. Энэ стандарт нь санхүүгийн тайлангууд материаллаг алдаа ба буруу тайлагналаас ангид илэрхийлэгдсэн эсэх талаар дунд түвшний баталгаа гаргах чиглэл удирдамж болдог. Аудитыг байгууллагын ажилтнуудаас асуулга тавьж харилцан ярилцах, санхүүгийн тайлан дахь тоон мэдээллүүдэд тулгуурласан шинжилгээ судалгаа харьцуулалт, тулган баталгаажуулалт хийх, давтан гүйцэтгэх, хөөн шалгах болон аудитын сорил горимуудаар хэрэгжүүлдэг.

Бид гэрээт ажлаа Аудитын тухай хуулийн зарчимд нийцүүлэн урьдчилан боловсруулсан төлөвлөгөөний дагуу гүйцэтгэнэ. Нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан бэлтгэхэд баримталсан зарчим сонгож хэрэглэсэн аргыг бүхэлд нь үнэлнэ. Удирдлагын шийдвэр үлэмж хэмжээний дүн бүхий тооцоолол онцлог үйл явдлуудын бүртгэл ба үйл явдлуудыг тусгайлан авч үзнэ.

Санхүүгийн тайлан ба нэмэлт тодруулгад тусгагдсан мэдээллийн талаар нотлох зүйл олж авахын тулд түүврийн болон бусад сорил горимуудыг ашиглана. Аудитын ажлын үр дүнд танай байгууллагын 2023.12.31-нээрх үлдэгдлийн тэнцэл, орлого, үр дүн болон мөнгөн гүйлгээ нь нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлангийн талаарх Монгол улсын хууль тогтоомж, Сангийн яамнаас баталж мөрдүүлсэн заавар аргачлалын дагуу үнэн бөгөөд шударгаар илэрхийлсэн эсэхийг тодруулан тайлагнах болно. Та бүхнээс бэлтгэж толилуулсан санхүүгийн тайланд хийсэн аудитын ажлын тайлангийн бодит байдал нь бидний хүлээх хариуцлага болно.

Аудитын ажлын онцлог, үйлчлүүлэгчийн бүртгэл, хяналтын онцлог, сул тал сөрөг нөлөөтэй бусад хүчин зүйлүүдээс шалтгаалан, залилан ба материаллаг алдаа бүхий тайлагналыг илрүүлэх, илрүүлэхгүй бийх тохиолдол гарахыг бид үгүйсгэхгүй. Зайлсхийх боломжгүй ийм эрсдэлүүд аудитын ажлын практикт түгээмэл байдаг. Бид ийм алдаа гаргахгүй байхыг эрхэмлэн, тодруулах шаардлагатай болон материаллаг алдаатай мэдээлэл, бусад зүй бус илрүүлэлтийн хувьд холбогдох тайлбар тодруулгыг та бүхнээс тухай бүрд нь авна.

Санхүүгийн тайланд хийх аудитын гэрээт ажлын талаар Талуудын бусад үүрэг хариуцлага, ажлын хугацаа, үйлчилгээний хөлс болон бусад асуудлыг аудитын ажлын гэрээгээр зохицуулна.

Танай байгууллагын 2023.12.31-нээрх тасалбар оны жилийн санхүүгийн зэрэгцүүлсэн мэдээллийн аудитын гэрээт ажлын талаар дээр дурдсан зарчмын зүйлүүд нь энэ ажлын тухай таны ойлголттой нийцэж байвал энэхүү захидлын илүү нэг хувьд гарын үсгээ зурж бидэнд ирүүлнэ үү.

Та бүхэнд амжилт хүсье. Баярлалаа

ХҮНДЭТГЭСЭН:

“Шонхор үнэлгээ Аудит” ХХК-ийн
Захирал



Д.Шийрэв

ХҮЛЭЭН АВСАН:

“ЛэндМН ББСБ” ХК -ийн
Гүйцэтгэх захирал



Ц.Ууганбаяр